

БАРИЛГА ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 03 дугаар сарын 02

Дугаар № 03

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай

Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс ТОГТООХ НЬ:

1. “Барилга” ХК-ийн 2020 оны үйл ажиллагааны талаархи хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг /цаашид ХЭХ гэх/ 2021 оны 04-р сарын 15-ны өдрийн 14.00 цагт байгууллагын хурлын танхимд хуралдуулсугай.
2. Хурлаар доорхи асуудлуудыг хэлэлцүүлэх:
 - Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тайлан
 - 2020 оны санхүүгийн тайлан
 - Хөндлөнгийн аудитын дүгнэлтийн тухай
 - ТУЗ-ийн гишүүдийг сонгох тухай
 - Байгууллагын тайлант оны үр дүн, ашиг хуваарилах тухай
 - Бусад
3. Хувьцаа эзэмшигчдийн хуралд бэлтгэх комиссыг доорх бүрэлдэхүүнтэй томилсугай:
Комиссын дарга – Ш.Эрдэнэбат /Гүйцэтгэх захирал/
Гишүүд – Б.Ариунтуяа /Хүний нөөцийн менежер/
Э. Батсүх /Ерөнхий нягтлан бодогч/
4. Комисст даалгах нь:
 - Байгууллагын ТУЗ, санхүүгийн болон хөндлөнгийн аудитын дүгнэлт, тайланг бэлтгүүлэх.
 - Байгууллагын 2021 оны үйл ажиллагааны чиглэл, бизнес төлөвлөгөөний гол үзүүлэлтийг бэлтгэж ХЭХ-д оруулах.
 - Хурлын зарыг Компанийн тухай хууль болон Санхүүгийн Зохицуулах Хорооноос гаргасан ХК-ийн ХЭХ-н зар хүргэх журмын зохих заалтуудын дагуу нийтэд мэдээлэх.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Л.ШАГДАРРАГЧАА

ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Б.АРИУНТУЯА